

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХОЛБОГДОХ ШҮҮХЭЭР ХЯНАН
ХЭЛЭЛЦЭГДЭЖ БАЙГАА 2018 ОНЫ ХЭРЭГ МАРГААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА**

2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар

А. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох 2018 онд шүүхэд хэлцэгдэж буй хэрэг, маргаан:

№	Шүүхийн нэр	Нэхэмжлэл гаргасан хугацаа	Хэргийн товч утга	Нэхэмжлэгчийн нэр	Хариуцагч, ИТ-ийн нэр	Анхан шатны шүүхийн шийдвэр	Давж заалдах шатны магадлал	Хяналтын шатны шүүхийн тогтоол	Тайлбар, үр дүн
Иргэний хэргийн анхан шатны шүүх									
1.	Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.09.07	Зам, тээвэр барилга, хот байгуулалтын яам, “Цахилгаан тээвэр” ОНӨААТҮГ-тай /хуучнаар/ байгуулсан “Цахилгаан тээврийн хэрэгсэл-12 ширхэг Доубус угсрах” ЦТХ-ДУ 2011/01/72 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх 12 доубуснаас нийлүүлэгдээгүй үлдсэн 2 доубусны үнэ болох 322,934,167.00 /гурван зуун хорин хоёр сая есэн зуун гучин дөрвөн мянга зуун жаран долоо/ төгрөг, алданги 161,467,083.00 /нэг зуун жаран нэгэн сая дөрвөн зуун жаран долоон мянга наян гурав/ төгрөгийг гаргуулах	Зам тээврийн хөгжлийн яам Г.Очхүү	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Зорчигч тээврийн нэгтгэлд холбогдох Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 14 цаг 00 минутад хуралдаж Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.3-д заасны дагуу бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.	Нэхэмжлэгч Зам, тээврийн хөгжлийн яам Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс хүлээн зөвшөөрч давж заалдах гомдолоо 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Давж заалдах шатны шүүхэд хүргүүлж ажиллав		Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Зорчигч тээврийн нэгтгэлд холбогдох иргэний хэргийг Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-д заасны дагуу дахин шийдвэрлүүлэхээр буцаав.
2.	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.12.16	“Монголын төмөр зам” ТӨХК-тай байгуулсан 2011 оны 1/002 тоот гэрээний дагуу Даланзадгад-Тавантолгой-Цагаан суварга-Сайншанд-БаруунУрт-Хөёт-	Нэхэмжлэгч Эко Гидро Гео ХХК	Хариуцагч “Монголын төмөр зам” ТӨХК Монгол Улсын Хөгжлийн банк Гуравдагч этгээдээр Зам,	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			

			Чойбалсан чиглэлд барих төмөр замын 1165 км трассын дагуух инженер-геологи, геотехник, гидрологийн судалгааны ажлын төсөвт өртгийн үйлдэгдэл 2,683,577,500 төгрөг гаргуулах		тээврийн хөгжлийн яам С.Мяндасмаа				
3.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2016.11.08	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгч 10,945,921,481 төгрөгийн хохирол гаргуулах тухай	ЗТХЯ Д.Оюунсүрэн С.Мяндасмаа	“Чайна гео инженеринг корпораци” ХХК	1. Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосныг нэхэмжлэгч тал эс зөвшөөрч Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан 2. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж хариуцагч “Чайна гео инженеринг корпораци” ХХКийн сөрөг нэхэмжлэлийн шаардлага болох 3.050.175.738 төгрөгийг гаргуулж хариуцагчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 18.367.631 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, нэхэмжлэгчээс 15.408.828.69 төгрөгийг гаргуулж хариуцагчид олгохоор шийдвэрлэв.	Давж заалдах шатны шүүхийн 2018.07.20-ны өдрийн шүүх хуралдаанаар Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Анхан шатны шүүхэд хэргийг буцаагаад байна.	Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг нэхэмжлэгч “Чайна гео инженеринг корпораци” ХХК нь эс зөвшөрч Хяналтын шатанд гомдол гаргасан байна.	
4.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.09.19	Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг гүйцэтгэх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4 705 118 456 37 /дөрвөн тэрбум долоон зуун таван сая нэг зуун арван найман мянга зуун тавин	Хурдны зам ХХК	Иргэний нисэхийн ерөнхий газар Бие даасан шаардлага гаргаагүй 3-дагч этгээдээр ЗТХЯ Б.Байгалмаа С.Мяндасмаа	“Хурдын зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний нисэхийн ерөнхий газарт холбогдох иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаанд Зам тээврийн хөгжлийн яам бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдэр оролцож /итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Мяндасмаа, Б.Байгалмаа/ нар 2018.09.05-ны өдөр шүүх хуралдаанд оролцов. Хариуцагч ИНЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тул гуравдагч этгээд хариуцагчийн эрх ашгийн хамгаалж шүүх	Нийслэлийн давж заалдах шатны шүүхэд бие даасан шаардлага гаргаагүй Зам, тээврийн хөгжлийн яам давж заалдах гомдол гарган 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хан-Уул дүүргийн анхан шатны шүүхэд хүргүүлээд байна. Нийслэлийн давж заалдах		

			зургаан төгрөг, гучин долоон мөнгө/ төгрөгний хохиролыг ИНЕГ-аас гаргуулах			хуралдаанд оролцов. Нэхэмжлэгчийн 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4 705 118 456 37 төгрөг гаргуулах шаардлага бүхий нэхэмжилснээс 425.765.839 төгрөг гаргуулах шүүхийн шийдвэр гаргав.	шатны шүүх хуралдаан 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.		
5.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018.04.02	Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км асфальтобетон хучилттай авто замын барилгын ажлын урьчилгаа төлбөр 663,480,000 /Зургаан зуун жаран гурван сая дөрвөн зуун наян мянга/төгрөг гаргуулах тухай	ЗТХЯ Б.Байгалмаа	"Нутгийн зам групп" ХХК	Анхан шатны шүүх хурал 2019 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 09:00 цагт товлогдов.			Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018.04.02-ны өдөр нэхэмжлэл хүргүүлэн, иргэний хэрэг үүссэн байна. Анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 11:00 цагт болов. Шүүх хуралдаанаар нэхэмжлэгч тал өмгөөлөгч авах, гэрч асуулах хүсэлт гаргасныг даргалагч шүүгч хүсэлтийг үндэслэл бүхий гэж үзэн хүсэлтийг хангаж, шүүх хурал хуулийн хугацаагаар хойшлогдов.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ

1	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.07.29	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өргөрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, нөхөн төлбөр гаргуулах тухай	"Жуулчин монгол наадам" ХХК	Засгийн газар, Барилга, хот байгуулалтын яам, ЗТХЯ С.Мяндасмаа	Анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн шүүх хуралд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "Хэргийн газрын үзлэг хийлгэх хүсэлт" гаргаж шүүх хурал хойшлогдоод байна. "Жуулчин монгол наадам" ХХК-ийн нэхэмжлэлтэй Засгийн газар, Барилга хот байгуулалтын яаманд холбогдох гуравдагч этгээдээр ЗТХЯ оролцсон захиргааны хэргийн шүүх хурал 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр болж Засгийн газрын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэв .	Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 18-ны хуралдаанаар 128/ШЗ2018/4100 дугаар захирамжийг хэвээр үлдээв		
2	Нийслэлийн		Засгийн газрын			Нүхт тур ХХК-ийн			Захиргааны хэрэг

	захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.3.16	2017оны 277 дугаар тогтоолын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах /Иргэний нисэхийн катерингийн үйлчилгээтэй холбоотой/	Нүхт тур	Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар Г.Очхүү	нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Үндэсний хөгжлийн газарт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 09 цагт хуралдаж Нүхт тур ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14-т заасны дагуу нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.		хянан шийдвэрлэх тухай хуулийн 84.1.5-д "... Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон бол хэргийн хянан шийдвэрлэхэд үл оролцох ба шүүх хурлаас өөрөө татгалзан гарах үүрэгтэй" гэж заасны дагуу хариуцагч тал шүүгчээс татгалзсаны үндсэн дээр шүүгч шүүх хуралдааныг хойшлуулав. Шүүх хуралдааны хугацаа товлоогүй байна.
3	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.01.19	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, нөхөн төлбөр гаргуулах тухай	Ашид арвин буян ХХК	Засгийн газар С.Мяндасмаа	Засгийн газарт холбогдох "Ашид арвин буян" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн шүүх хуралдаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, нэхэмжлэгчийн эвлэрлийн гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн зөвшөөрч ажиллав. Эвлэрлийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.		
4	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.06.05	ЗГ-ын 2010 оны газрын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоолыг өөрт хамаарах хэсгийг хүчингүй болгох тухай	Очит-Уул ХХК	Засгийн газар С.Мяндасмаа	Анхан шатны шүүхэд хариу тайлбарын төсөл боловруулаад байна. Анхан шатны шүүх хурал 2018.09.10-ны өдөр шинжээч томилохоор шийдвэрлэж, тус иргэний хэргийг түтгэлзүүлэв.		Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.08.23-ны өдрийн шүүх хуралдаан хариуцагчийн өмгөөлөгчийн хүсэлтээр хойшлогдов .
5	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх /Анхан шатны шүүх хуралдаан зарлагдаагүй байна/	2018.06.20	"2016, 2017 онуудад Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн замын барилгын ажилд тавигдсан техникийн хяналт буюу зөвлөх үйлчилгээний зардал болох нийт 1.325.000.013 төгрөг төлөхгүй,	Эм Си Пи Си Жи Ар ХХК	ЗТХЯ Б.Байгалмаа, С.Мяндасмаа	Анхан шатны шүүхэд хариу тайлбар 2018.08.03-ны өдөр хүргүүлээд байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.10.01-ны өдрийн урьдчилсан хэлэлцүүлэгээр 2018.10.11-ний өдрийн 14:30-д шүүх хуралдаан товлогдов. Шүүх хурал 2018.11.07-ны өдрийн 13 цагт болж хойшлогдов		

			хугацаа алдагдуулж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамны эс үйлдлийг хууль бус болохыг тогтоох, 2016, 2017 оны замын барилгын ажилд байнгын техник-технологийн хяналтын ажлын нийт үнэ 1.325.000.013 төгрөгийн төлбөр гаргуулах тухай						
--	--	--	---	--	--	--	--	--	--

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХОЛБОГДОХ
2018 ОНД ШҮҮХЭЭР ХЭЛЭЛЦЭГДЭЖ ДУУСГАВАР БОЛСОН ХЭРГИЙН СУДАЛГАА**

Б. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох 2018 онд шүүхээр хэлцэгдэж дуусгавар болсон хэрэг, маргаан:								
Иргэний хэргийн анхан шатны шүүх								
1.	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.09.20	Зам-Үүдийн Зорчигч тээврийн авто вокзал болон гаалийн агуулахын барилга угсралтын "№АТ/2012-02/132 тоот гэрээний дагуу барилга угсралтын ажлын баталгаажсан гүйцэтгэлээс суутгасан барьцаа 100.266.300.00 төгрөгийг зээлийн барьцаанд тавьсан үйлчилгээний зориулттай хоёр ширхэг үл хөдлөх хөрөнгийг зээлийн барьцаанаас чөлөөлөх шийдвэр гаргаж, "Хаан банк" ХХК-д хүргүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яаманд" даалгах	Бридж констракшн ХХК	ЗТХЯ С.Мяндасмаа Г.Очхүү	Анхан шатны 2018 оны 01 дүгээр сарын 08-ны шүүх хурлаар нэхэмжилсэн 123.266.300.00 төгрөгийн шаардлага бүхий нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, ЗТХЯ-нд гэрээний гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгосон албан бичгийг Хаан банкинд хүргүүлэхийг даалгасан шийдвэр гаргасан.		Анхан шатны 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШШ2018/00061 дугаар шийдвэрээр нэхэмжлэгч талын нэхэмжилсэн 123.266.300.00 төгрөг бүхий нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, ЗТХЯ-нд гэрээний гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгосон албан бичгийг Хаан банкинд хүргүүлэхийг даалгасан. Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
			Өндөрхаан-			Анхан шатны	Анхан шатны	Нэхэмжлэгч Дээд шүүхийн 2018

2.	Улсын дээд шүүх	2017.09.17	Чойбалсан чиглэлийн 95,4 км хатуу хучилттай авто замын Багц - III БОЛОХ 27,75 км замын ажлын гэрээний үнийн өсөлтийн зөрүү 1.503.860.293 төгрөг гаргуулах тухай	Гашууны гол групп ХХК	ЗТХЯ С.Мяндасмаа Б.Байгалмаа	шүүх хуралдаан 2017.10.24-ний өдөр болж 896,751,361 төгрөгийг хангаж, 607.108.932 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв	шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгов.	“Гашууны гол групп” ХХКийн ДЗШ-ны шүүхийн магадлал эс зөвшөөрч гаргасан гомдлыг хянаад Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгов.	оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 001/ХТ2018/00555 дугаар тогтоолоор Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож, хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгов. Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
3.	Монгол улсын дээд шүүх	2016.05.12	Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.488 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн үнийн өсөлтийн зөрүү 2.484.870.155 төгрөг гаргуулах тухай	Хотгор зам ХХК	ЗТХЯ С.Мяндасмаа	Анхан шатны шүүхийн 2018.04.25-ны өдрийн шүүх хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.	Нийслэлийн иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 6 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалав.		Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 181/ШШ2018/00967 дугаар шүүхийн шийдвэрээр Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.488 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн үнийн өсөлтийн зөрүү 2.484.870.155 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн шүүх хуралд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгов.

4.	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2016.12.08	Мөрөн-Тариалан чиглэлийн 29,3 км хатуу хучилттай автозамын зураг төсөвт зааснаас өөрчлөгдсөн тул үнийн өсөлтийн зөрүүг ЗТХЯ-наас 3.620.,082.820., төгрөг гаргуулж, УТХ 18.258.364 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч “Пик девелопмент”ХХК-д олгох тухай	Пик девелопмент	ЗТХЯ Б.Байгалмаа С.Мяндасмаа Д.Оюунсүрэн	1. Иргэний хэргийн Анхан шатны шүүхийн 2017.02.09-ний өдрийн 181/ШЗ2017/02525 шийдвэрээр “шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн. 2.“Пик девелопмент”ХХК-ийн нэхэмжлэлтэй ЗТХЯ-д холбогдох иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018-09-19-ний өдөр хуралдав. Шүүх хуралдаанд ЗТХЯ-ны /итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Мяндасмаа, Б.Байгалмаа Д.Оюунсүрэн/ нар оролцов. Нэхэмжлэгчийн шаардлага Мөрөн-Тариалан чиглэлийн 29,3 км хатуу хучилттай автозамын зураг төсөвт зааснаас нэмэлт зардал, гарсан тул үнийн өсөлтийн зөрүүг ЗТХЯ-наас 3.620.082.820 /гурван тэрбум зургаан зуун хорин сая наян хоёр мянга найман зуун хорин/төгрөгний нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.	Нэхэмжлэгч тал давж заалдах шатны шүүхэд 2018.10.22-ны өдөр гомдол гаргасантай холбогдуулан хариуцагч тал давж заалдах шатны шүүхийн хуралдаанд бэлтгэн хариу тайлбар боловсруулаад байна.		Нэхэмжлэгч шинжээч томилуулах хүсэлт тавьсан, мөн гэрч оролцуулах хүсэлт гаргасны дагуу шүүгч захирамж гаргаж Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлээд байна. 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдөр шинжээчийн дүнэлт гарсан байна. 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр шинжээчийн дүгнэлттэй холбоотойгоор ЗТХЯ-аас хүсэлт шүүхэд хүргүүлсэн. 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 13.30-минутад зарлагдсан шүүх хурал прокурор 06 дугаар сарын 7,8,13,14,15-нд сургалттай, ЗТХЯ-ын ахлах мэргэжилтэн С.Мяндасмаа нь гадаадад томилолттой тул шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан тул шүүх хуралдаан 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 10.00 цагт болж хойшлогдов. Шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 13:30-т хурал товлогдов.
5.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018.03.30	“Хархорин-Хужирт” чиглэлийн 36,8 км хатуу хучилттай авто замын хоёрдугаар хэсэг 15,4 км замын барилгын ажил”-	ЗТХЯ Б.Цэнд	“Аваргас ХХК”	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2018.04.13-ны 182/ШЗ2018/03389 дугаар захирамжаар			

			ыг гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 276,000,000 /хоёр зуун далан зургаан сая төгрөг /-ийг гаргуулах тухай			хариуцагчийн хаяг тодорхойгүйгээс иргэний хэрэг үүсгэхээс татгалзав..			
6.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018.04.07	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар хороонд баригдах 1.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажил"-ын урьдчилгаа санхүүжилт болох 31.400.000 /гучин нэгэн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг гүйцэтгэгч "Композит Асмо" ХХК-аас гаргуулах.	ЗТХЯ Д.Оюунсүрэн	"Композит Асмо" ХХК	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018.04.18-ны өдөр нэхэмжлэл хүргүүлэн, иргэний хэрэг үүссэн байна. Нэхэмжлэгч тал хаягтаа оршин суудаггүй тул шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгов.			

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх

1.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.09.29	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Иргэн Р.Батдэлгэр	Засгийн газар ЗТХЯ С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
2.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх	"Си эн эм аудит" ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.

			онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай		ТНБД С.Мяндасмаа	шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			
3.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Хөх уул Алтайд ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
4.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг	Пластрийн ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.

			хүчингүй болгуулах тухай			нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			
5.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Хүлгийн сүлд ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
6.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Хаан шадав ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
7.	Нийслэлийн		Төв аймгийн			Захиргааны			Зам, тээврийн

	захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Дэлхийн цамхаг ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
8.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Цаглашгүй эрдэм ХХ	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон тохиолдолд нөхөн олговор шаардахгүй" гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
9.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг	Олдхаммер ХХК	Засгийн газар ЗТХЯ-ны ТНБД С.Мяндасмаа	Захиргааны хэргийн анхан шатны 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт давхцалгүй газар олгосон			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.

			өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай			тохиолдолд нөхөн олговор шаардахгүй” гэж нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнийг үндэслэн Эвлэрийн гэрээ байгуулж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.			
10	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2016.12.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	“Зуу Хаан” ХХК, “Цаглашгүй эрдэм” ХХК, Р.Батдэлгэр	Засгийн газар	Анхан шатны шүүх хуралдаан 2017.02.24-нд шүүх хурал болж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
11	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2016.04.10	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	“Зуу Хаан” ХХК	Засгийн газар	Анхан шатны шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож Шийдвэр гаргасан.			Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
12.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.09.10	БНПУ дахь Төмөр замын төлөөлөгчийн ажилд эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин олгуулах тухай	Иргэн С.Баяраа	ЗТХЯ С.Мяндасмаа	Анхан шатны шүүх хариу тайлбар хүргүүлээд байна.	Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй	Давж заалдах шатны шүүхээс Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, ЗТХЯ-ны талд магадлал гараад байна.	Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2018 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанаар С.Баярын нэхэмжлэлийг бүхэлд нь

							болгож шийдвэрлэсэн.		хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв. /Улсын дээд шүүхийн тогтоол албажих гараагүй болно. / Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэр гарсан байна.
13.	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.10.12	Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын албан тушаалд эгүүлэн томилж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.08.04-ний 153 дугаар тушаалыг илт хууль бус гэж тооцуулах, ажилгүй байсан хугацааны цалин бусад нэмэгдлийг нөхөж олгуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын нөхөн бичилт хийлгэх тухай	Иргэн Ж.Цолмон	ЗТХЯ Б.Байгалмаа Д.Цэцэгмаа Б.Очхүү	Анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн шүүх хурлаар нэхэмжлэгчийн шаардлагыг бүрэн хангав.			Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 128/ШШ2018/0210 дугаар шийдвэрээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.08.04-ний 153 дугаар тушаалыг илт хууль бус гэж тооцуулах, ажилгүй байсан хугацааны цалин бусад нэмэгдлийг нөхөж олгуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын нөхөн бичилт хийлгэх тухай нэхэмжлэгчийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэв. Нэхэмжлэгч Ж.Цолмонгийн талд шийдвэр гарсан.
14	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2015.04.20	Сайншанд-Баруун урт-Чойбалсан чиглэлийн бүтээн байгуулалтын эхний ажил хөрс хуулалтын ажлын хөлс 4 849 289 927 (дөрвөн тэрбум наман зуун дөчин есөн сая хоёр зуун наян мянга есөн зуун хорин долоон) төгрөг нийт алданги 2 424 644 963 (хоёр	Нэхэмжлэгч Кэй Эйч Эн Ар ХХК	Хариуцагч Монголын төмөр зам" ТӨХК Монгол Улсын Хөгжлийн банк Гуравдагч этгээдээр Зам, тээврийн хөгжлийн яам С.Мяндасмаа	Хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01155 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК болон "Кэй Эйч Эн Ар" ХХК-ийн хооронд байгуулсан 2011 оны 1/006 тоот ажил гүйцэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус гэж			

			тэрбум дөрвөн зуун хорин дөрвөн сая зургаан зуун дөчин дөрвөн мянга есөн зуунжаран гурав) нийт 7 273 934 890 /долоон тэрбум хоёр зуун далан гурван сая есөн зуун жаран гурван/ төгрөг гаргуулах			үзэн, Монголын Төмөр зам ТӨХК-иас 3,353,532,660 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэлийн шаардлагаас 3,920,402,230 төгрөгийг болон хариуцагч Монгол Улсын хөгжлийн банк ХХК-д холбогдох нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Монголын Төмөр Зам ТӨХК-иас улсын тэмдэгтийн хураамж 16,925,613 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэв.			
15	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.01.05	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тушаалыг хүчингүй болгуулах, Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага дахь Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны төлөөлөгчийн албан тушаалд эгүүлэн тогтоолгох тухай Ажилгүй байсан хугацааны цалин 160,000,000 төгрөг гаргуулах	Иргэн С.Баяраа	Зам, тээврийн хөгжлийн сайд ЗТХЯ С.Мяндасмаа			УДШ-ийн 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 237 дугаар тогтоолоор "Нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож" шийдвэрлэсэн.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тушаалыг хэвээр үлдээсэн.ЗТХЯ-ны эрх ашгийг хамгаалж, цалин болох 160,000,000 сая төгрөгийн зардалыг хэмнэв.	
16	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.3.16	-Улаанбаатар Дархан чиглэлийн 204,6км авто замын ТЭЗҮ, зураг төслийг хүлээн авахыг даалгах -Улаанбаатар Дархан чиглэлийн 204,6км авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах	Эм Си Пи Си Жи Ар ХХК	Зам, тээврийн хөгжлийн яам Д.Оюунсүрэн	Шүүх хуралдаан товлогдоогүй байна. Шүүх хуралдаан 2018.08.15-нд зарлагдав. - Анхан шатны шүүх хурал 2018 оны 8 дугаар сарын 15-ны зарлагдаж хариуцагчийн			"Эм Си Пи Си Жи Ар" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох захиргааны хэргийн шүүх хурал 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж гэрчийн мэдүүлэг

			нийт ажлын төлбөр 3.096,369.326 төгрөг олгохыг ЗТХЯ-нд даалгах			хүсэлтээр шүүх хуралдаан хойшлогдов. Шүүх хуралдаан товлогдоогүй байна.			болон хэрэгт авагдсан нотлох баримтуудад үндэслэн нэхэмжлэлийн шаардлагын бүрэн хангаж шийдвэрлэсэн.
17	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.09.05	Баян-Өлгий аймгийн авто замын өргөтгөл, шинэчлэлт 10.4 км” авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн шалгаруулалтыг хууль бус болохыг тогтоолгож, сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож дахин тендер зарлуулах.	Түмэн дэлгэрэх ХХК	Итгэмжлэгдсэн төлөөлөгч ЗТХЯ-ны АЗБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д. Энхтуяа	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар 128/ШШ2018/0740 шийдвэрээр нэхэмжлэгч “Түмдэлгэрэх ” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсанаар тус захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.			Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ЗТХЯ-ны ХХ-ийн мэргэжилтэн С.Мяндасмаа, Б.Цэнд нар томилогдов. Нэхэмжлэлийг хүлээн авч танилцав. Хариу тайлбарыг Захиргааны хэргийн шүүхэд хүргүүлж ажиллав.
18	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.06.18	Хөшигийн олон улсын нисэх буудлын хурдны замтай давхцалтай газрыг чөлөөлөхтэй холбогдуулан нөхөн төлбөр болох 511.000.000 төгрөг гаргуулах тухай	Домогт угсаа ХХК	Хариуцагч: Нийслэлийн засаг дарга, Нийслэлийн авто замын газар, Хан-Уул дүүргийн засаг дарга Гуравдагч этгээд: ЗТХЯ	Нэхэмжлэгч ЗТХЯ-тай холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилсөн тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгов.			Нэхэмжлэлийг хүлээн авч танилцаж, холбогдох хариу тайлбарыг 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Захиргааны хэргийн шүүхэд хүргүүлэв.

ТАЙЛБАР:

1. Нийт **35** хэргээс

Иргэний **12** хэрэг,

Захиргааны **23** хэрэг байна.

Үүнээс ангилвал:

Засгийн газрыг төлөөлж **17 хэрэг**

ЗТХЯ-г төлөөлж **18 хэрэг** байна.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажилллагаа дуусгавар болсон **25** хэрэг байна. Үүнд:

Иргэний **6** хэрэг,

Захиргааны **19** хэргийг тус тус шийдвэрлэсэн байна.

Үүнээс ангилвал:

Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа **13 хэрэг**,
ЗТХЯ-г төлөөлж **12 хэрэг** байна.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **10** хэрэг байна. Үүнд:

Иргэний **5** хэрэг

Захиргааны **5** хэрэг байна.

Үүнээс ангилвал:

Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа **4 хэрэг**,
ЗТХЯ-г төлөөлж **6 хэрэг** байна.

4. Зам, тээврийн хөгжлийн яамны хамгаалагдсан эрх ашгийн хөрөнгийн хэмжээ:

1. Иргэний хэрэгт:

“Бридж констракшн” ХХК **20.913.527**

“Гашууны гол групп” ХХК **1.526.734.096**

“Пик девелопмент” ХХК-ийн **3.638.351.184**

“Хотгор зам” ХХК **2.507.015.669**

“Хурдны зам” ХХК **4.303.644.048**

Иргэн С.Баяраа 160.000.000 төгрөг,

НИЙТ 12.156.658.524 /арван хоёр тэрбум нэг зуун тавин зургаан сая зургаан зуун тавин найман мянга таван зуун хорин дөрөв/ төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалж шүүхийн шийдвэр гаргуулаад байна.

2. Захиргааны хэрэгт:

Захиргааны 11 хэргийг Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэрлэгдсэн байна. Үүнд:

- Иргэн С.Баяраагийн нэхэмжэлтэй захиргааны хэрэг,
- Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өртрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай 10 захиргааны хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн.

Захиргааны 3 хэрэгт нэхэмжлэгчийн шаардлагыг хангаж шийдвэрлэгдэж, шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

- Иргэн Ж.Цолмонгийн нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох захиргааны хэрэг,
- “Кэй Эйч Эн Ар” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монголын төмөр замд холбогдох, гуравдагч этгээдээр Зам, тээврийн хөгжлийн яам

- “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох захиргааны хэрэг,

5. Шүүхээр хэлэлцэгдэж байгаа хэргийн **2018 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 12 дугаар сарын 07-ны өдөр хүртлэх** хуралдааны шийдвэрлэлт:

1/. “Хурдны зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний нисэхийн ерөнхий газарт холбогдох, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр ЗТХЯ оролцсон Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн шүүх хуралдаанд нэхэмжлэгч талаас итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Энхсүх, ЗТХЯ-ны итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Мяндасмаа, Б.Байгалмаа нар оролцсон. Тус шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

2/. ЗТХЯ-ны нэхэмжлэлтэй “Нутгийн зам групп” ХХК-нд холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр болж, хариуцагч тал өмгөөлөгч нэмж авсантай холбогдуулан хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан тул шүүх хуралдаан 2019 оны 01 дүгээр сарын 04-ний 09:00 цагт болж хойшлогдов.

6. Хуулийн хэлтсийн мэргэжилтнүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй байдал:

- 1.Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Мяндасмаа -**11**
- 2.Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Г.Очхүү-**2**
- 3.Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Байгалмаа-**5**
- 4.Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунсүрэн -**4** тус тус төлөөлөн оролцож байна.

Боловсруулсан:

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Байгалмаа